



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/011/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2025 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amariargalo@audit.gov.mn

Аудитор С.Намшир

Утас: 70272248 Цахим хаяг: namshirs@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Туунмод сум
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.03.24 № 01/2025
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН
ЗАСАГ ДАРГА А.ЭРДЭНЭБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг тогтвортой ахиулах, оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилго тавьж ажиллажээ. Тайлант онд сумын түүхт 100 жилийн ойг тохиолдуулан 1,898,385.3 мянган төгрөгийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг улс, орон нутгийн төсвөөр хийж гүйцэтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Батсүмбэр сумын шилжих үлдэгдлээс ЗДТГ-т автомашин 69,950.0 мянган төгрөг, бүжинхэн цэцэрлэгийн дээврийн их засвар 50,083.0 мянган төгрөг, Баянголын сургууль, цэцэрлэгийн сантехникийн засвар 101,000.0 мянган төгрөг, ЗДТГ-ын дээврийн их засвар 79,032.7 мянган төгрөг, Мандал багийн хаягжуулалтын ажил 20,000.0 мянган төгрөг, сумын 3 багт цамхагт гэрэл 19,900.0 мянган төгрөг, ОНХС-ийн хөрөнгөөр наадмын талбайн засвар 155,780.5 мянган төгрөг, мандал багийн гудамжны засмал зам 142,926.5 мянган төгрөг, чимэглэлтэй гэрэл 136,322.6 мянган төгрөг, Баянгол багт спорт заал 116,900.0 мянган төгрөг, багуудад худаг 30,000.0 мянган төгрөгөөр тус тус хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын 2024 оны Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 47 зорилт, 187 арга хэмжээтэй хэрэгжилт 87.2 хувийн үр дүнтэй дүгнэгдсэн, байгууллагын

412506448

гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 11 зорилт, 38 арга хэмжээтэй хэрэгжилт 85,8 хувьтай, төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилт 6 зорилт, 27 арга хэмжээтэй хэрэгжилт 89,2 хувьтай тус тус дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,420,257.00	2,378,075.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,512,698.70	1,698,985.00
33	АВЛАГА	685,944.80	404,909.50
35	БАРАА МАТЕРИАЛ	221,613.40	274,180.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,485,406.00	3,524,390.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,485,406.00	3,524,390.80
39200	Биет хөрөнгө	1,821,394.60	2,712,247.60
39300	Биет бус хөрөнгө	664,011.40	812,143.30
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,905,663.00	5,902,466.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	44,790.80	42,935.30
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	44,790.80	42,935.30
41300	Өглөг	44,790.80	42,935.30
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,860,872.10	5,859,530.70
51	Засгийн газрын хувь оролцоо	4,860,872.10	5,859,530.70
51200	Хуримтлагдсан үр дүн	3,521,612.90	4,520,271.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,905,663.00	5,902,466.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,493,072.40	5,776,951.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,309,206.90	1,945,812.00
110	Орлогын албан татвар	925,805.90	1,514,683.30
1100	Хувь хүний орлогын албан татвар	965,805.90	1,514,683.30
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-40,000.00	0
113	Хөрөнгийн албан татвар	107,551.00	167,564.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	275,849.90	263,564.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	639,073.50	1,959,654.60
120	Нийтлэг татварын бус орлого	629,413.50	1,168,063.60
122	Тусламжийн орлого	9,660.00	791,591.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,544,792.10	1,871,484.80
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,511,629.20	3,930,663.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,133,095.50	3,632,340.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,992,284.50	3,046,338.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	681,916.40	1,014,101.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,822.90	125,987.80

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,922.60	708,409.40
2104	Хангамж, бараа материалын зардал	65,759.40	86,398.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,732.80	27,769.90
2107	Томилолт, зочны зардал	7,138.50	8,869.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,335.10	16,955.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,070,656.70	1,057,847.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,140,811.00	586,001.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	378,533.70	298,322.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	981,443.20	1,846,288.20
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,608.00	847,629.60
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	975,835.20	998,658.60

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
Код	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,369,109.60	5,108,632.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,309,206.90	1,945,812.00
110	Орлогын албан татвар	925,805.90	1,514,683.30
1100	Хувь хүний орлогын албан татвар	965,805.90	1,514,683.30
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-40,000.00	0
113	Хөрөнгийн албан татвар	107,551.00	167,564.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	275,849.90	263,564.50
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	35,173.60	38,002.80
1181	Газрын төлбөр	148,014.70	150,686.10
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	92,661.60	74,875.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	509,366.20	1,247,526.10
120	Нийтлэг татварын бус орлого	499,706.20	455,935.10
122	Тусламжийн орлого	9,660.00	791,591.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,550,536.60	1,915,294.20
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,140,415.30	2,890,340.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,140,415.30	2,890,340.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,999,604.30	2,297,779.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	681,659.50	1,014,143.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,976.60	125,648.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,466.40	739,427.80

2104	Хангамж, бараа материалын зардал	67,544.00	62,746.10
2105	Нормативт зардал	205,733.30	201,129.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,143.60	36,959.50
2107	Томилолт, зочны зардал	7,105.50	8,716.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,271.60	15,893.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	885,703.80	93,115.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,140,811.00	592,560.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,228,694.30	2,218,292.40
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	915,803.60	1,990,856.10
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	915,803.60	1,990,856.10
2200	Дотоод эх үүсвэрээр	915,803.60	1,990,856.10
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-915,803.60	-1,990,856.10
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-125,518.00	-41,150.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	125,518.00	41,150.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	187,372.80	186,286.30
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,325,326.00	1,512,698.70
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,512,698.70	1,698,985.00

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,886,169.00	0	3,886,169.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,132.00	0	-1,132.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,885,036.90	0	3,885,036.90
9	Тайлант үеийн үр дүн	975,835.20	0	975,835.20
10	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	4,860,872.10	0	4,860,872.10
11	2024 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	4,860,872.10	0	4,860,872.10
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,860,872.10	0	4,860,872.10
19	Тайлант үеийн үр дүн	998,658.60	0	998,658.60
20	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,859,530.70	0	5,859,530.70

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,863,294.30	3,904,488.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,165,002.70	1,975,014.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,143,424.40	1,953,823.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	926,792.70	915,179.46
210101	Үндсэн цалин	561,482.10	549,080.59
210102	Нэмэгдэл	331,947.90	329,159.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,482.00
210104	Урамшуулал	25,442.70	31,689.19
210105	Гэрээт ажлын хөлс	7,920.00	2,768.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,849.00	113,081.90
210201	Тэтгэврийн даатгал	78,777.30	78,132.51
210202	Тэтгэмжийн даатгал	9,267.80	9,193.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,634.00	4,596.65
210204	Ажилгүйдлийн даатгал	4,634.00	4,527.26
210205	Эрүүл мэндийн даатгал	18,535.90	16,631.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	858,899.00	739,427.75
210301	Гэрэл, цахилгаан	87,892.50	66,608.82
210302	Түлш, халаалт	750,127.00	658,166.26
210303	Цэвэр, бохир ус	20,879.50	14,652.68
2104	Хангамж, бараа материалын зардал	60,722.70	57,103.73
210401	Бичиг хэрэг	4,366.00	4,489.47
210402	Тээвэр, шатахуун	28,227.20	27,681.78
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,363.00	2,717.06
210404	Ном, хэвлэл	3,766.50	1,218.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	21,000.00	20,996.63
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,328.00	36,959.53
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500.00	2,489.50
210604	Урсгал засвар	34,828.00	34,470.03
2107	Томилолт, зочны зардал	7,841.00	7,686.00
210702	Дотоод албан томилолт	7,841.00	7,686.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,476.00	13,017.77
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,428.00	5,142.03

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,339.00	1,339.00
210803	Даатгалын үйлчилгээ	454.70	397.13
210804	Тээврийн хэрэгслийн татвар	211.00	211.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	443.30	397.62
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,000.00	4,931.00
210807	Газрын төлбөр	600.00	600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,516.00	71,367.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	118,881.00	69,732.66
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,635.00	1,635.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,578.30	21,191.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,578.30	21,191.10
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,608.00	6,608.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,050.30	8,050.30
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,920.00	6,532.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,547,991.60	1,888,323.38
220001	Барилга байгууламж	310,000.00	116,900.03
221001	Их засвар	661,198.70	502,735.14
222001	Тоног төхөөрөмж	101,578.10	71,701.01
223001	Бусад хөрөнгө	1,475,214.80	1,196,987.20
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150,300.00	41,150.00
230001	Эргэж төлөгдөх зээл	150,300.00	41,150.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,863,294.30	4,304,689.41
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	654,466.40	-
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	654,466.40	-
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,272,637.70	3,387,717.82
320001	Орон нутгийн төсвөөс	2,272,637.70	2,750,724.62
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	636,993.20
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	986,190.20	125,380.59
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,300.00	125,380.59
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	835,890.20	-
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	950,000.00	791,591.00
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	950,000.00	791,591.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	386,267.60
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	499,004.69

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он Т3 цэвэр дүн	Тайлант он Т3 цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	272,491.60	397,401.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	272,491.60	294,884.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	260,033.18	136,306.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	44,213.02	96,124.92
210101	Үндсэн цалин	7,133.47	25,131.44
210102	Нэмэгдэл	33,765.48	70,993.48
210104	Урамшуулал	3,314.08	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,977.79	11,806.20
210201	Тэтгэврийн даатгал	2,744.85	8,113.44
210202	Тэтгэмжийн даатгал	318.22	954.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	254.58	477.30
210204	Ажилгүйдлийн даатгал	63.64	452.21
210205	Эрүүл мэндийн даатгал	596.49	1,808.72
2104	Хангамж, бараа материалын зардал	563.00	5,112.50
210402	Тээвэр, шатахуун	563.00	5,112.50
2107	Томилолт, зочны зардал	-	850.00
210702	Дотоод албан томилолт	-	850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,139.91	2,560.07
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,139.91	2,560.07
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	210,139.46	19,853.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	210,139.46	19,853.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,458.42	158,577.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	36,559.89
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	36,559.89
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,458.42	122,017.96
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,232.69
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	12,458.42	120,785.27
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	102,516.56
2200	Дотоод эх үүсвэрээр	-	102,516.56
221001	Их засвар	-	102,516.56
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	272,491.60	397,401.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	272,491.60	397,401.40

131103	ЗГНХ,ЗДНХ,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	204,103.66
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,827.25	175,949.24
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	111,664.35	17,348.50

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1			1			
3	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
4	Эмийн эргэлтийн сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
6	Баянгол цэцэрлэг	1		1					
7	Бүжин цэцэрлэг	1		1					
8	Ойн анги	1		1					
	НИЙТ	8	1	7		1			

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЭЭС	1	1,015.6			1	1,015.6	1	1,015.6		
ЗДТГ	1	1,335.6			1	1,335.6	1	1,335.6		
ИТХ	1	225.3			1	225.3	1	225.3		
Бүжин цэцэрлэг	1	5,176.0			1	5,176.0	1	5,176.0		
Баянгол цэцэрлэг	2	2,400.0			2	2,400.0	2	2,400.0		
ОНХС	1	99,890.1	1	99,890.1			1	99,890.1		
Ойн анги	1	120.5			1	120.5	1	120.5		
Дүн	8	110,163.1	1	99,890.1	7	10,273.0	8	110,163.1		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	5	116,922.3	1	820.3	1	3,000.0	3	113,102.0
Хоршоо хөгжүүлэх сан	2	640,135.3			1	53,323.0	1	586,812.3
Эргэлтийн эмийн сан	2	325.0	1	325.0	1			
Ойн анги	3	51,365.5			1	1,176.8	2	50,188.7
ИТХ	1						1	
Дүн	13	808,748.1	2	1,145.3	4	57,499.8	7	750,103.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn